

モンゴル国際交流員着任のごあいさつ

初めまして、モンゴルから参りました、ドゥゲルジャブ・ノミンチメドと申します。ノミンと呼んでください。モンゴルの西のアルタイ山脈があるコビアルタイ県のデルゲルという小さな村に生まれ育ちました。1999年、日本に国費留学生として来日し、東京で1年間日本語を勉強した後、2000年から2004年まで北海道大学で経営学を勉強しました。北海道はモンゴルと季節などが似ていて、北海道の人々もみんな親切だったのであつという間に時間が過ぎ、帰国することになっていました。

モンゴルに戻った後、日系の建設会社で10年間働き、そのあと5年間は弟が設立した会社の経営に携わっていましたが、この度、また日本で、しかも北海道で活躍する機会に恵まれてとても光栄です。コロナで全世界が自粛ムードとなり、様々な事業がキャンセルになっていますがモンゴルと日本、モンゴルと滝川市の交流がもっと盛んになり、その発展に私も貢献できればと思っています。よろしく願いいたします。



Сайн байна уу? Монголоос ирсэн Дүгэржавын Номинчимэд байна. Товчхоноор Номин гэж дуудаарай. Монголын баруун зүгт Алтай нуруу байдаг Говь-Алтай аймгийн Дэлгэр гэдэг жижигхэн суманд төрж өссөн. 1999 онд Японд тэтгэлэгт хөтөлбөрөөр ирж Токиод нэг жил япон хэл сурсныхаа дараа 2000 оноос 2004 он хүртэл Хоккайдогийн Их Сургуульд эдийн засгаар сурсан. Хоккайдо бол Монголтой цаг агаар нь адилхан, хүмүүс ч гэсэн бүгдээрээ эелдэг байсан учраас нэг л мэдэхэд нутаг буцахаар болсон байсан.

Монголд буцаж ирснийхээ дараа Японы хөрөнгө оруулалттай компанид 10 жил ажиллан түүний дараа 5 жил дүүгийнхээ компанид туслалцсан. Энэ удаа дахиад Японд, Хоккайдоод ирэх боломж ирсэнд маш их баяртай байна. Короно гээд дэлхий нийтээр хөл хориотой, олон үйл ажиллагаанууд цуцлагдаж байгаа ч Монгол ба Япон, Монгол ба Такикава хотын хооронд хамтын ажиллагаа улам өргөжин, тэрхүү хөгжилд янз бүрийн хэлбэрээр хувь нэмрээ оруулахыг хүсч байна.

<滝川市についての感想>

滝川市には家族とともに来滝しました。子供二人が滝川市内の中学校に通い、多くの日本人の子供が親切に接してくれて感銘を受けました。滝川市に来て間もないですが、至る所に綺麗な花が咲き、街路が整っており、思った以上に町が広くて道に迷う程でした。日本の他の町は駅の周辺が栄えていますが、滝川市は郊外に大型スーパーなどが集中しているところが不思議でした。

Такикава хотод гэр бүлээрээ ирсэн. Хоёр хүүхэд минь Такикава хотын дунд сургуульд сурч олон япон хүүхдүүд эелдэгээр тусламж дэмжиж байгаад сэтгэл хөдөлж байна. Такикава хотод ирээд удаагүй ч хаа сайгүй цэцэг дэлгэрч, хотын гудамж ч гэсэн цэвэрхэн замдаа төөрмөөр өргөн уудам хот байсан. Бусад японы хотууд өртөөний эргэн тойрон нь хөгжсөн байхад томоохон их дэлгүүрүүд нь Такикава хотын захаар төвлөрсөн байсан нь сонирхолтой байсан.

<やってみたいイベント>

モンゴルは日本でよく知られている国の一つですが、日本人がまだまだ知らない部分がたくさんあります。モンゴルの文化、政治体制、遊牧民の生活、子供たちの伝統的な遊びなどを滝川市民の皆さんに紹介したいと思っています。モンゴル及び滝川市の地域交流の為になるようないろいろなイベントに関わっていきたいです。

<Цаашид зохион байгуулахыг хүсч буй арга хэмжээ>

Монгол Японд сайн танигдсан улс орнуудын нэг ч гэсэн Япон хүмүүсийн мэдэхгүй зүйл олон байгаа гэж бодож байна. Тэрхүү Монголын соёл, улс төр, нүүдэлчдийн амьдрал, хүүхдүүдийн үндэсний тоглоом наадгай зэргийг Такикава хотын иргэдэд танилцуулъя гэж бодож байна. Монгол болон Такикава хотын орон нутгийн хөгжилд хувь нэмэр болох олон янзын арга хэмжээнүүдэд оролцохыг хүсч байна.

<趣味>

私の趣味はサイクリングと読書と映画鑑賞です。サイクリングと言ってもそれほどスポーツ的なものではなく、自転車でいろいろなところを見学することが好きなので、滝川市及びその周辺の町を自転車で巡りたいです。本は特に歴史の本が好きなので、日本の皆さんとモンゴルと日本の歴史について語り合いたいです。

<Хобби>

Миний сонирхол бол дугуй унах, ном унших, кино үзэх юм. Дугуй гэж байгаа ч тийм спортын хэмжээнд унадаггүй бөгөөд дугуйгаар олон газрыг явж үзэх дуртай болохоор Такикава хот болон түүний эргэн тойрны хот тосгодыг дугуйгаар тойрч үзнэ гэж бодож байгаа. Унших дуртай ном маань түүхийн сэдэвтэй учраас Япон хүмүүстэй Монголын болон Японы түүхийн талаар ярилцмаар байна.